



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ИРГЭДИЙН ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

2025 оны II улирал

2025 оны 7 дугаар сар



I. ХУРААНГУЙ


“Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ны мэдээллийг 2025 оны 6 дугаар сарын 16-аас 7 дугаар сарын 02-ны хооронд цуглуулж, Улаанбаатар хотын иргэдийн байршил, хүйс, насны бүлэг, өрхийн орлогын бүтцийг төлөөлөх 1,002 иргэнийг хамруулж, түүвэр судалгааны мэдээллийг боловсрууллаа. Судалгааны гол үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

- Судалгаанд Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт оршин суудаг, 26-55 насны дээд боловсролтой, эмэгтэй иргэд түлхүү оролцлоо.
- Түүвэр судалгаанд хамрагдсан иргэдийн хариултаас хүлээгдэж буй инфляцыг тооцвол (Зураг 1):

Инфляцын хүлээлт	2025 оны III улиралд	2026 оны II улиралд
Дундаж хүлээлт	9.8%	10.9%
Медиан хүлээлт	10.2%	11.3%

- Ирэх улирлын өрхийн зардал, хуримтлалын хүлээлт өмнөх улирлын түвшинтэй адил өрхийн санхүүгийн тэнцэл, хуримтлал бага зэрэг буурах хүлээлттэй байна.
- Ажил эрхлэлт буурах төлөвтэй гэсэн хүлээлт давамгайлж байна. Мөн иргэдийн хувьд эдийн засаг удаашрах, төгрөгийн ханш үргэлжлэн сулрах хүлээлттэй гарлаа.
- Ирэх улиралд зээлийн хүү өсөх хүлээлт илүү давамгайлж байна.

Зураг 1. Инфляцын хүлээлт




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

II. ИНФЛЯЦЫН ХҮЛЭЭЛТ


Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн чанарын хариултад үндэслэн өнгөрсөн хугацааны үнийн өсөлтийн мэдрэмжийн индексийг тооцоход өнгөрсөн 3 болон 12 сарын хугацааны хувьд ойролцоо утгатай гарч, өмнөх улирлын судалгааны үр дүнгээс бага зэргийн өссөнөөр “инфляц өссөн” мужид хэвээр хадгалагдлаа (Зураг 2).

Ирэх хугацааны инфляцын хүлээлтийн индексийн хувьд ч мөн адил ирэх улирлын болон ирэх 1 жилийн хүлээлтийн индексийн утгууд өмнөх улирлаас бага зэргийн өссөн бөгөөд ирэх 1 жилийн хүлээлтийн индексийн утга харьцангуй өндөр гарлаа. Улмаар, индексийн утга тус бүр “инфляц өснө” мужид хадгалагдаж, цаашид үнэ өсөх хандлагыг илэрхийлж байна (Зураг 3).

Зураг 2. Инфляцын мэдрэмжийн индекс¹



Зураг 3. Инфляцын хүлээлтийн индекс




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх хугацааны хүлээлтийн талаар иргэдийн тоон хариултад үндэслэн инфляцын дундаж утгыг тооцоход 2025 оны III улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.5 нэгж хувиар буурч **9.8%**, 2026 оны II улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар буурч **10.9%**-тай тус тус гарлаа (Зураг 4). Харин инфляцын хүлээлтийн тоон хариултаас медиан² утгыг тооцоход 2025 оны улирлын хүлээлт өмнөх улирлаас 1.3 нэгж хувиар буурч **10.2%**, 2026 оны II улирлын хүлээлт өмнөх улирлаас 0.7 нэгж хувиар буурч **11.3%**-тай гарлаа (Зураг 5). Мөн 2024 оны 6 сараас хойш гурван улирал дараалан нэмэгдээд байсан инфляцын хүлээлтийн утга тайлант улиралд бага зэрэг буурсан төлөвтэй гарлаа (Зураг 6).


¹ Бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өнгөрсөн хугацаатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдсөн талаар мэдрэмжийг асууж, “маш ихээр өссөн”, “нэлээдгүй өссөн”, “ажмаар өссөн”, “хэвэндээ” болон “буурсан” гэсэн хариултуудыг [3;-1] утгаар нормчилж чиглэлийн индексийг тооцсон болно.

² Тоон асуулгын хариултаас [Nicholas J. Cox \(2009\)](#)-ийн боловсруулсан “Хагас тархалтын функц” болон “Симметрик шугаман интерполяци медиан” аргачлалыг ашиглан тоон хүлээлтийн тархалт болон медиан утгыг тооцсон болно.

Зураг 4. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан & дундаж утга, **ирэх 3 сар**




Зураг 5. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлтийн медиан & дундаж утга, **ирэх 12 сар**




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Иргэдийн тоон хариултаас харахад ирэх 3 болон 12 сарын инфляцын хүлээлтийн тархалт одоогийн түвшнээс нэмэгдэх чиглэлд буюу баруун тийш хэлбийлттэй байна (Зураг 7).

Зураг 6. Тоон хариултаас тооцсон инфляцын хүлээлт, дундаж утга



Зураг 7. Инфляцын хүлээлт, тоон хариултын тархалт



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх хугацааны хүлээлтийг чанарын хариултын тархалтаар харьцуулахад, 2025 оны III улиралд “өнөөгийн түвшнээс илүүтэйгээр өснө” гэх хүлээлт өмнөх улирлаас 12.3 нэгж хувиар буурч **57.5%**, “өнөөгийн түвшнээс ижил хувиар өснө” гэх хүлээлт 8.0 нэгж хувиар өсөж **26.8%**, харин “өнөөгийн түвшнээс багаар өснө” гэх хүлээлт 2.7 нэгж хувиар өсөж чанарын хариултын **13.0%**-ийг тус тус эзэлж байна (Зураг 8).


Зураг 8. Инфляцын хүлээлт, чанарын хариултын тархалт *ирэх 3 сар*



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх хугацааны хүлээлтийн талаар иргэдийн чанарын хариултын тархалтыг харьцуулахад, 2026 оны II улиралд “өнөөгийн түвшнээс илүүтэйгээр өснө” гэх хүлээлт өмнөх улирлаас 12.8 нэгж хувиар буурч **64.4%**, “өнөөгийн түвшнээс ижил хувиар өснө” гэх хүлээлт 9.5 нэгж хувиар өсөж **23.9%**, харин “өнөөгийн түвшнээс багаар өснө” гэх хүлээлт 1.6 нэгж хувиар өсөж чанарын хариултын **9.5%**-ийг тус тус эзэлж байна (Зураг 9).


Зураг 9. Инфляцын хүлээлт, чанарын хариултын тархалт *ирэх 12 сар*




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх хугацааны тоон хүлээлтийг насны бүлгээр харьцуулахад, 2025 оны III улиралд 55 дээш настай иргэдийн хүлээлт 0.1 нэгж хувиар буурч **10.4%**, 36-55 настай иргэдийн хүлээлт 1.4 нэгж хувиар буурч **9.7%**, 36 доош настай иргэдийн хүлээлт 1.5 нэгж хувиар буурч **9.6%** тус тус гарлаа (Зураг 10). Харин 2026 оны II улиралд 55 дээш настай иргэдийн хүлээлт 0.4 нэгж хувиар өсөж **11.2%**, 36-55 настай иргэдийн хүлээлт 0.4 нэгж хувиар буурч **11.0%**, 36 доош настай иргэдийн хүлээлт 0.3 нэгж хувиар буурч **10.6%**-тай гарлаа (Зураг 11).

Зураг 10. Инфляцын хүлээлт, Насны бүлгээр (ирэх 3 сар)




Зураг 11. Инфляцын хүлээлт, Насны бүлгээр (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа

Ирэх хугацааны тоон хүлээлтийг орлогын ангиллаар харьцуулахад, 2025 оны III улиралд 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой иргэдийн хүлээлт 1.0 нэгж хувиар буурч **10.3%**, 1.6-3.0 сая төгрөгийн орлоготой иргэдийн хүлээлт 1.0 нэгж хувиар буурч **9.6%**, 1.6 сая төгрөгөөс доош орлоготой иргэдийн хүлээлт 1.5 нэгж хувиар буурч **9.5%**-тай гарлаа (Зураг 12). Харин 2026 оны II улиралд 3.0 сая төгрөгөөс дээш орлоготой иргэдийн хүлээлт 0.6 нэгж хувиар буурч **11.4%**, 1.6-3.0 сая төгрөгийн орлоготой иргэдийн хүлээлт 0.1 нэгж хувиар буурч **10.8%**, 1.6 сая төгрөгөөс доош орлоготой иргэдийн хүлээлт 1.9 нэгж хувиар буурч **10.0%**-тай гарлаа (Зураг 13).

Зураг 12. Инфляцын тоон хүлээлт, Орлогын ангиллаар (ирэх 3 сар)



Зураг 13. Инфляцын тоон хүлээлт, Орлогын ангиллаар (ирэх 12 сар)




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа


III. ӨРХИЙН САНХҮҮГИЙН БАЙДАЛ

Өрхийн орлогын хүлээлт сүүлийн 2 улирал дараалан өссөн бол энэ удаад өмнөх улирлын утгаас 0.07 нэгжээр буурснаар сөрөг утгатай буюу 2025 оны III улиралд өрхийн орлого бага зэрэг буурах хүлээлттэй гарлаа (Зураг 14). Харин өрхийн зардлын хүлээлт өмнөх улирлын утгуудтай ижил тэлэх чиглэлд байгаа бөгөөд өмнөх улирлын утгаас бага зэрэг нэмэгдсэн байна (Зураг 15). Мөн бодит цалин болон өрхийн хэрэглээний өсөлт саарч байгаа нь цаашид өрхийн санхүүгийн тэнцэл хүндрэлд орж болзошгүй төлөвтэй байна.

Зураг 14. Өрхийн орлогын хүлээлт, ирэх 3 сар



Зураг 15. Өрхийн зардлын хүлээлт, ирэх 3 сар



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Өрхүүд хадгаламжийн хүлээлт сүүлийн 5 улирал дараалан буурах чиглэлд өндөр хэвээр гарлаа (Зураг 16). Өрхийн орлого бага зэрэг нэмэгдсэн боловч өрхийн хэрэглээ 2024 оноос хойш өндөр өсөлттэй байсан нь хуримтлал хийх боломжийг хязгаарлажээ. Гэсэн хэдий ч иргэдийн хугацаатай хадгаламж 2025 оны 6 дугаар сарын эцэст 19.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 20 хувиар өссөн байна. Нөгөө талаас, банкнуудаас авсан иргэдийн хэрэглээний зээлийн үлдэгдэл мөн хугацаанд 12.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 20 орчим хувиар өсжээ. Ингэхдээ хэрэглээний чанаргүй зээлийн эзлэх хувь 3.9%-тай байгаа ч сүүлийн 4 улирал дараалан өсөж байгаа нь цаашид анхаарах үзүүлэлт болж байна.


Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-оос эрхлэн гаргадаг “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны 2025 оны I улирлын нэрлэсэн дүнгээр өрхийн дундаж орлого болон зардлын зөрүүгээр өрхийн санхүүгийн тэнцэл 38.5 мянган төгрөгийн алдагдалтай гарчээ. Өөрөөр хэлбэл, өрхүүд хэрэглээгээ хуримтлалаас илүүтэйгээр зээлээр санхүүжүүлж байна.

Ирэх улиралд санхүүгийн байдлаа төлөвлөхөд хүндрэлтэй байгаа талаар судалгаанд оролцогчдын дийлэнх нь дурджээ. Энэ нь эдийн засгийн тодорхой бус байдал өндөр хэвээр байгааг илтгэж байна (Зураг 17).


Иргэдийн банкнаас авсан хэрэглээний зээлийн үлдэгдэл, түүний жигнэсэн дундаж хүү болон хугацаагаар зээлийн сарын дундаж төлбөрийг тооцоход 2025 оны 6 дугаар сарын эцсийн байдлаар 678.3 мянган төгрөг болж байна. Энэ нь өрхийн сарын дундаж нэрлэсэн орлогын 24

орчим хувьтай тэнцэх бөгөөд энэхүү үзүүлэлт сүүлийн 1 жилийн хугацаанд тасралтгүй нэмэгдсээр түүхэн хамгийн өндөр түвшинд хүрээд байна.

Зураг 16. Өрхийн хадгаламжийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 17. Санхүүгийн байдлын төлөвлөлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк, ҮСХ


IV. ИРГЭДИЙН МАКРО ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХҮЛЭЭЛТ

Ажил эрхлэлтийн үзүүлэлт өмнөх улирлын утгаас эрс буурч, ирэх улиралд ажил эрхлэлт нэлээдгүй буурах хүлээлт давамгайллаа (Зураг 18). Гэсэн хэдий ч ҮСХ-ны мэдээгээр ажиллагчдын тооны өсөлт сүүлийн 5 улирал дараалан буураад байсан бол 2025 оны эхний улиралд бага зэрэг сэргэлт ажиглагджээ. Мөн эдийн засгийн өсөлтийн хүлээлтийн үзүүлэлт өмнөх улирлаас нэлээдгүй буурч -0.36 утгатай буюу эдийн засаг агших хүлээлттэй гарлаа. Энэ нь 2021 оноос хойших хамгийн муу үзүүлэлт болж байна (Зураг 19).

Зураг 18. Ажил эрхлэлтийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 19. Эдийн засгийн байдлын талаарх хүлээлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ


2025 оны II улиралд 1 ам.доллар дунджаар 3,564 төгрөгтэй тэнцэж, өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар суларсан байна. Төгрөгийн ханш ирэх улиралд үргэлжлэн суларна гэж иргэдийн дийлэнх үзэж байна (Зураг 20).

Зээлийн хүүний хувьд ирэх улиралд хүү өсөх хүлээлт иргэдийн дунд давамгайлж, өмнөх улирлын утгаас бага зэрэг буурлаа (Зураг 21). Иргэдэд банкнаас олгосон хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хүү сүүлийн 2 жилд төдийлөн өөрчлөлт ороогүй буюу 2025 оны II улирлын байдлаар 17.3%-тай байна.

Зураг 20. Гадаад валютын ханишийн хүлээлт, ирэх 3 сар



Зураг 21. Зээлийн хүүний талаарх хүлээлт, ирэх 3 сар




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, Монголбанк


V. ХАВСРАЛТ

“Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа”-ний мэдээллийг 2025 оны 6 дугаар сарын 16-наас 7 дугаар сарын 02-ны өдрүүдэд Улаанбаатар хотод оршин суугаа насанд хүрсэн, өмнөх улирлуудын судалгаанд оролцож байсан иргэдээс утсаар ярилцлага хийх байдлаар (817) болон дурын утасны дугаарлалт үүсгэж³ масс мессеж илгээх байдлаар санамсаргүй түүвэрлэлтээр (198) цуглуулсан бөгөөд нийт 1,015 иргэдээс судалгааны мэдээлэл цуглууллаа. Үүнээс иргэдийн давхардсан мэдээллийг хасаж тооцоход судалгаанд оролцсон 1,002 иргэд нь эх олонлогоо бүрэн төлөөлөх чадвартай байна. Тухайлбал, судалгаанд оролцогчдын оршин суугаа хаягийг ҮСХ-оос зарласан 2023 онд Улаанбаатарт оршин суугаа хүн ам (насанд хүрсэн иргэд)-ын бүтэцтэй харьцуулахад харгалзан пропорциональ байна (Зураг 22). Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргийн иргэд судалгаанд оролцогчдын 38 хувийг бүрдүүлсэн бол энэ удаагийн судалгаанд оролцогчдын 62% нь эмэгтэй, 38% нь эрэгтэй байна (Зураг 23).

Зураг 22. Судалгаанд оролцогчдын оршин суугаа хаяг



Зураг 23. Судалгаанд оролцогчдын хүйс




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ


Мөн судалгаанд оролцогчдыг насны ангиллаар харвал 36-55 насны иргэд 50 хувийг бүрдүүлсэн бөгөөд Улаанбаатарт оршин суугаа хүн амын насны бүлэгтэй харгалзан нийцтэй байна. Боловсролын хувьд дээд болон бүрэн дунд боловсролтой иргэд тус судалгаанд түлхүү хамрагдлаа (Зураг 24-Зураг 25).

³ “Random Digit Dailing” аргачлалыг энэ улирлын түүвэр судалгаанаас эхлэн ашиглаж байгаа бөгөөд энэхүү аргачлалаар түүврийн тодорхой хэсгийг бүрдүүлснээр судалгаанд оролцогч иргэдийн мэдээллийг шинэчлэх, шинэ оролцогчдыг элсүүлж, мэдээллийн санг өргөжүүлэх, насны бүлгийн залуу төлөөллүүдийн хувьд судалгаанд оролцох магадлалыг нэмэгдүүлэх, түүвэр судалгааны мэдээлэл цуглуулах цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг давуу талтай байна. Одоогоор нийт түүврийн 20 хүртэл хувийг энэхүү аргачлалаар мэдээлэл цуглуулахыг зорьж байна.

Зураг 24. Судалгаанд оролцогчдын насны ангилал



Зураг 25. Судалгаанд оролцогчдын боловсролын байдал




Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ

Ажил эрхлэлтийн хувьд энэ удаагийн судалгаанд хувийн болон төрийн байгууллагад ажилладаг иргэд голлон хамрагдлаа (Зураг 26). Судалгаанд оролцогч иргэдийн өрхийн орлогын бүлэг нь ҮСХ-оос зохион байгуулдаг “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-ны өрхүүдийг мөнгөн орлогоор бүлэглэсэн хамгийн сүүлийн буюу 2025 оны I улирлын үр дүнтэй харгалзан нийцтэй байна (Зураг 27).

Зураг 26. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлт



Зураг 27. Судалгаанд оролцогчдын орлогын бүлэглэлт



Эх сурвалж: Иргэдийн инфляцын хүлээлтийн түүвэр судалгаа, ҮСХ